

Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тэвчр 9 дэвсгэр, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
короо, Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

"Ард Кредит" ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Ард кредит ББСБ" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягт"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Ард кредит ББСБ" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй болно.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.


Б.О.ОРГАВАН
УДИРДАХ ПАРТНЕР
УЛААНБААТАР ХОТ
1118274081
Монгол улс, Улаанбаатар хот
2024 оны 3 дугаар сарын 28

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
Хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,223,162	5,027,668
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,358,464	789,329
Харилцагчдад олгосон зээл	47,941,596	40,038,098
Бусад санхүүгийн хөрөнгө	3,327,068	2,855,132
Бусад эргэлтийн хөрөнгө	8,549,712	7,736,922
Үндсэн хөрөнгө	867,847	938,892
Биет бус хөрөнгө	2,737,697	652,707
Нийт хөрөнгө	72,005,546	58,038,748
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	15,133,326	11,211,776
Өрийн бичгээрх өглөг	-	6,886,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	103,722	
Бусад эх үүсвэр	24,161,193	13,641,277
Бусад өр төлбөр	11,702,396	8,250,273
Өр төлбөрийн нийт дүн	51,100,637	39,989,326
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	8,152,792	8,152,734
Бусад өмч	1,915,611	1,598,872
Хуримтлагдсан ашиг	10,836,506	8,297,816
Эздийн өмчийн дүн	20,904,909	18,049,422
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	72,005,546	58,038,748

Ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	2023 он	2022 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	13,019,411	11,339,294
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(6,887,980)	(6,513,600)
Хүүгийн цэвэр орлого	6,131,431	4,825,694
Хүүгийн бус орлого	4,730,883	5,945,035
Хүүгийн бус зардал	(7,672,701)	(6,335,565)
Цэвэр хүүгийн бус орлого	(2,941,818)	(390,530)
Болзошгүй эрсдэлийн зардал	(2,840,634)	(2,530,969)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,639,593	575,759
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(37,201)	(45,389)
Татварын өмнөх ашиг (алдагдал)	2,951,371	2,434,565
Орлогын татварын зардал	(432,710)	(375,341)
Татварын дараах ашиг (алдагдал)	2,518,661	2,059,224
Бусад дэлгэрэнгүй орлого	308,643	(10,365,666)
Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл	308,643	(10,365,666)
Хэрэгжсэн олз		-
Нийт дэлгэрэнгүй орлого	2,827,304	(8,306,442)
Нэгж хувьцаанд ногдох ашиг	0.009	0.007